

СЭЛЭНГЭ АЙМГИЙН 2020-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛИЙН ТАЙЛАН

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин үр дүн	Шаардлагатай хөрөнгийн эхмжээ, хөрөнгийн эх үүсвэр	Хэрэгжилт
7	ЗГҮАХ-ийн 4.1.1. Алсын хараа -2050 5.3.14	Улсын бүртгэлийн хэлтсийг архив, үйлчилгээний байртай болгох асуудлыг судалж, мэдээллийн аюулгүй байдал, хадгалалт хамгаалалтыг сайжруулна	-Архивын үйлчилгээний байртай болсон эсэх	Иргэд тав тухтай орчноос түргэн шуурхай үйлчилгээ авах нөхцөл бүрдсэн байна.	Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр	Улсын бүртгэлийн хэлтсийг архив, үйлчилгээний байртай болох талаар Улсын болон орон нутгийн төсөвөөс хөрөнгө оруулалт хийгдээгүй болно.
8	ЗГҮАХ-ийн 4.1.1. Алсын хараа -2050 5.3.14	Иргэний тоон гарын үсэгт суурилсан иргэний үнэмлэхийг бүртгэлийн үйлчилгээнд нэвтрүүлнэ.	Үйлчилгээнд нэвтрүүлсэн эсэх	Иргэд тоон гарын үсгээ ашиглан бүртгэлийн үйлчилгээ авах нөхцөл бүрдсэн байна.	Улсын болон орон нутгийн төсөв	Иргэдэд тоон гарын үсэг олгох, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх сурталчлан аймгийн хэмжээнд 2025 онд 68051 иргэнд тоон гарын үсэг олгоод байна. Улсын бүртгэлийн зөөврийн тоног төхөөрөмжөөр бүртгэлийн үйлчилгээ үзүүлдэг 2 сум / Баруунбүрэн, Түшиг/ сум, хорих ангиудад үйлчилгээ үзүүлдэг / Мандал, Сайхан/ сум 4 тосгон / Рашаант, Дулаанхаан, Түнхэл, Бугант/-д иргэний-4063 , эд хөрөнгийн -63, хуулийн этгээдийн нэрийн батагаажилт -14, эрхийн улсын бүртгэлийн нийт 2760 бүртгэл бүртгэсэн байна.

9	ЗГҮАХ-ийн 4.1.1. Алсын хараа -2050 5.3.14	Бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ.	Цахимжуулса н хувь	Иргэд улсын бүртгэлийн зарим үйлчилгээг цахимаар авах нөхцөл бүрдсэн байна.	Улсын болон орон нутгийн төсөв	Иргэний улсын бүртгэлд 32687 бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хөтөлж иргэн, хуулийн этгээдэд холбогдох 10478 лавлагаа олгожээ. Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт заасны дагуу засаг захиргааны нэгжийн харьяалал харгалзахгүйгээр 2838 бүртгэлийн үйлчилгээ үзүүлж 5305 лавлагаа олгосон байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 3935 бүртгэл хөтөлжээ. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлэр газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 6676, газар өмчлөх эрхийн 6324 нийт 13000 мэдүүлгийг хүлээн авч бүртгэжээ.
---	--	---	-----------------------	--	--------------------------------------	--

ТАЙЛАН ГАРГАСАН: СЭЛЭНГЭ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ЗАХИРГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЗОЛ-ЭРДЭНЭ

